

Хичээлийн хөтөлбөр

“Ногоон эдийн засгийн үндэс” Цахим хичээл



1	Удиртгал.....	1
2	Зорилтод бүлэг	1
3	Сургалтын зорилго	2
4	Сургалтын арга зүй, хэлбэр	2
5	Сертификат	3
6	Хичээлийн бүтэц ба агуулга	3
7	Техникийн шаардлага	6

1 Удиртгал

Улс орны эдийн засаг, бидний амьдралын хэв маяг ногоон хөгжлийн зам руу орох шаардлагатай гэдэгтэй ихэнх хүмүүс санал нэгтэй байдаг.

Одоогийн эдийн засгийг ногоон эдийн засаг болгоно гэж яг юуг хэлж байна вэ? Тогтвортой хөгжлийг бий болгох, дэмжих ямар боломжууд байна вэ? Ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд бидэнд ямар бэрхшээлүүд тулгарч байна вэ?

Эдгээр асуултуудад хэрхэн хариулах талаар бодож эхэлсэн бол та эхний алхмаа хийсэн гэсэн үг. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш “21-р зууны эдийн засгийн хөгжилд тэргүүлэх үүрэг гүйцэтгэгч нь тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг дэмжигчид байх болно” гэж онцлон тэмдэглэсэн.

Энэхүү цахим хичээл нь үнэ төлбөргүй бөгөөд тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн талаарх үндсэн асуултуудад хариулт өгөх зорилготой. Тус цахим хичээл нь Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ буюу PAGE) байгууллагын тусламжтайгаар бэлтгэгдсэн. НЭЗТТ нь НҮБ-ын 5 байгууллагын хамтарсан хөтөлбөр юм, үүнд: Байгаль орчны хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжлийн хөтөлбөр, Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Сургалт судалгааны хүрээлэн багтана. НЭЗТТ нь 2030 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд улс орнуудын эдийн засгийн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд тогтвортой хөгжлийн асуудлыг тусгах, дэмжих үүрэгтэй (www.un-page.org).

2 Зорилтод бүлэг

Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн талаар ерөнхий ойлголттой болохыг хүссэн хүн бүрт зориулсан энгийн, товч тодорхой, сүүлийн үеийн мэдээллийг тус цахим хичээл оруулсан. Тус цахим хичээл дараах оролцогч талууд сонирхон судлах нь зүйтэй. Үүнд:

- Төв болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, яам, тамгын газрын төрийн албан хаагчид
- Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагад ажилладаг байгаль орчны чиглэлийн мэргэжилтнүүд, менежерүүд
- Их, дээд сургуулийн багш нар, эрдэмтэн судлаачид, оюутнууд
- Сонирхсон бусад хүмүүс

3 Сургалтын зорилго

Энэхүү цахим хичээл үзсэнээр суралцагч нь тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх үндэслэл, үндсэн зарчмын талаар өргөн ойлголттой болно. Дэлхийн болон үндэсний хэмжээнд нүүрстөрөгчийн ялгарал багатай, нөөцийг үр ашигтай ашигласан, нийгмийн тэгш хүртээмжтэй хөгжлийг бий болгоход тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга зам, боломжуудыг тус хичээлээр авч үзнэ.

Тус цахим хичээл судалснаар, суралцагчид дараах ур чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Тэгш, хүртээмжтэй ногоон эдийн засгийн тухай ойлголт, үндсэн зарчим, үндэслэлийг харьцуулан авч үзэх,
- Улс орны эдийн засгийг ногоон эдийн засагт шилжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, шаардлагатай нөхцлийг тодорхойлох,
- Эдийн засгийн голлох салбаруудад ногоон эдийн засгийн асуудлыг тусгахад тулгарч буй бэрхшээл болон боломжийн талаар судлах,
- Тэгш, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд жишиг болохуйц улс орны хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөлтийн талаар авч үзэх,
- Тэгш, хүртээмжтэй ногоон эдийн засгийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын хөтөлбөр, санаачилгуудыг олж мэдэх.

4 Сургалтын арга зүй, хэлбэр

Тус цахим хичээл нь ямар нэгэн багшгүйгээр өөрөө суралцах хөтөлбөрийн дагуу хийгдсэн болно. Энэхүү и-хичээл нь 5 хичээлээс бүрдэх ба эдгээрийг үзсэнээр сургалтын зорилгод хүрэх болно. 5 хичээл тус бүр нь агуулгын хувьд бие даасан бүтэцтэй. Суралцагч нь 5 хичээлийг дарааллаар нь үзэхийг бид санал болгож байгаа ч өөрийн сонирхсон хичээлээ түрүүлж үзэх боломжтой. Хичээлийн явцад тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн талаар илүү гүнзгийрүүлэн суралцахыг хүсвэл, хичээл тус бүрт ашигласан материалын эх сурвалж, бүтээлүүд, тэдгээрийн талаарх мэдээллийг оруулсан болно. Нэр томъёоны тайлбар хэсэгт техник хэллэг, нэр томъёог багтаав.

Хичээл болгон интерактив хичээлийн слайд, видео бичлэг болон асуултанд хариулах даалгавартай. Нэг интерактив хичээл нь дунджаар 30 слайдаас бүрдэх бөгөөд үүнд жишээн дээр суралцахуй, видео бичлэг, вэб холбоосууд, дасгал ажлууд багтсан. Нэг хичээлийг ойролцоогоор 1 цагийн хугацаанд үзнэ.

Хичээл бүрийн эхэнд видео бичлэг байх бөгөөд тухайн бичлэгт хоёр найз тухайн хичээлтэй холбоотой асуудлын талаар ярилцана. Хоёр найз хоорондоо хичээлийн агуулгын хүрээнд эдийн

засаг, нийгэм, байгаль орчны асуудлыг, мөн тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн асуудлыг өдөр тутмын амьдралд хэрхэн нийцүүлж ойлгох тухай ярилцдаг. Энэ хоёр хүн бол бодлого боловсруулагч эсвэл их, дээд сургуулийн профессор биш харин улс орны эдийн засаг хэрхэн байгалийн нөөцийг үр ашигтай ашигласан, нийгмийн тэгш хүртээмжийг сайжруулсан, нүүрстөрөгчийн ялгарал багатай эдийн засагт шилжиж болохыг сонирхсон жирийн л хүмүүс.

Асуултанд хариулах даалгавраар тухайн хичээлийг судалснаар сургалтын зорилгод хүрсэн эсэхийг шалгана. Эдгээр даалгаврыг хэзээ ч гүйцэтгэж болно. Нэг даалгаврыг хамгийн ихдээ 3 удаагийн оролдлогоор гүйцэтгэх боломжтой. Асуултанд хариулах 5 даалгаврыг 70%-иас дээш амжилттайгаар хийж гүйцэтгэснээр энэхүү и-хичээлийг бүрэн дүүргэснийг баталгаажуулах сертификатыг цахим хуудаснаас татан авах боломжтой болно.

Суралцагч бүр тус и-хичээлийг судалсны дараа санал асуулгын маягтыг бөглөх шаардлагатай болно.

5 Сертификат

Суралцагч нь тус хичээлийг үзээд 5 хичээл тус бүрийн асуултанд хариулах даалгаврыг амжилттай гүйцэтгэсний дараа сертификат авна.

6 Хичээлийн бүтэц ба агуулга

Тус цахим хичээл нь 5 хичээлээс бүрдэнэ.
Үүнд:

1. Өнөөгийн нөхцөл байдал – Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх үндэслэл
2. Арга хэрэгсэл – Бүтцийн өөрчлөлт хийх нөхцлийг бүрдүүлэх
3. Зорилго – Ногоон эдийн засагт шилжих боломж бүхий салбарууд
4. Зорилгодоо хүрэх арга зам – Бодлогын зорилгодоо хүрэх стратеги боловсруулах, төлөвлөлт хийх нь
5. Байгаль орчныг хамгаалах нь - Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын хөтөлбөр, санаачилгууд

1-р Хичээл: Өнөөгийн нөхцөл байдал – Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх үндэслэл

Сургалтын зорилго

Энэхүү хичээлийг үзсэнээр суралцагч дараах ур чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Эдийн засгийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ байгаль орчин, нийгмийн нөхцөл байдлыг сайжруулахад хэрхэн нөлөөлдөг талаар хэлэлцэх
- Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэх үндэслэлийг тодорхойлох
- Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засаг болон 2030 Хөтөлбөрийн хоорондох уялдаа холбоог тодорхойлох

Хэсгүүд

1. Эдийн засгийн эргэн тойронд
2. Ногоон эдийн засагт шилжих үндэслэл
3. 2030 хөтөлбөр ба тэгш хүртээмжтэй ногоон эдийн засаг

2-р Хичээл: Арга хэрэгсэл – Бүтцийн өөрчлөлт хийх нөхцлийг бүрдүүлэх

Сургалтын зорилго

Энэхүү хичээлийг үзсэнээр суралцагч дараах ур чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд тохиромжтой бодлогын арга хэрэгслийн хоорондын ялгааг гаргах,
- Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн санхүүжилт чухал ач холбогдолтой болохыг тайлбарлах,
- Ногоон эдийн засагт шилжихэд иргэд болон албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой болохыг харуулах.

Хэсгүүд

4. Төрийн санхүүгийн чиг хандлагыг ухаалаг болгох нь
5. Тохиромжтой эрх зүйн орчныг бүрдүүлэх нь
6. Олон улсын эрх зүйн механизм
7. Хувийн санхүүжилтийг татан оролцуулах нь
8. Чадавхыг бэхжүүлэх замаар өөрчлөлтийг бий болгох нь

3-р Хичээл: Зорилго – Ногоон эдийн засагт шилжих боломж бүхий салбарууд

Сургалтын зорилго

Энэхүү хичээлийг үзсэнээр суралцагч дараах ур чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Ногоон эдийн засагт шилжих боломж ихтэй салбаруудыг тодорхойлох
- Ногоон эдийн засагт шилжих боломжтой голлох салбаруудад тулгарах бэрхшээл ба боломжуудыг нэрлэх
- Ногоон эдийн засагт шилжихэд шаардлагатай бодлогын арга хэрэгслийг тодорхойлох

Хэсгүүд

1. Тогтвортой хөгжлийн асуудлыг улс орны түвшинд авч үзэх нь
2. Байгалийн капиталд хөрөнгө оруулах нь
3. Бүтээгдсэн капиталд хөрөнгө оруулах нь

4-р Хичээл: Зорилгодоо хүрэх арга зам – Бодлогын зорилгодоо хүрэх стратеги боловсруулах, төлөвлөлт хийх нь

Сургалтын зорилго

Энэхүү хичээлийг үзсэнээр суралцагч дараах ур чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Ногоон эдийн засагт шилжих оролцогч талуудын үүргийг тодорхойлох
- Оролцоог хангахад чиглэгдсэн арга зүй, арга хэрэгслийг тодорхойлох
- Улс орны бодлого, стратеги, төлөвлөлтийн жишээг илэрхийлэх

Хэсгүүд

1. Ногоон шилжилт хийхэд талуудыг оролцуулах нь
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтөнд ногоон эдийн засгийн асуудлыг тусгах нь

5-р Хичээл: Байгаль орчныг хамгаалах нь - Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын хөтөлбөр, санаачилгууд

Сургалтын зорилго

Энэхүү хичээлийг үзсэнээр суралцагч дараах ур чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын хөтөлбөр, санаачилгуудыг тодорхойлох
- Ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд Хөгжлийн санхүүгийн байгууллагуудын оруулах хувь нэмэр, санаачилгуудыг тодорхойлох
- Дэлхийн болон бүс нутгийн түвшинд хэрэгжиж байгаа санаачилгуудаас суралцах

Хэсгүүд

1. Ногоон эдийн засагт шилжихэд туслах олон улсын санаачилгууд
2. Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудал
3. Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засгийн асуудал ба дэлхийн хандлага

7 Техникийн шаардлага

Интернетийн хөтөч програм:

- Сургалтын материалыг үзэхдээ Firefox 50 ба түүнээс дээш үзүүлэлттэй интернетийн хөтөч програм ашиглавал хамгийн сайн ажиллана (дараах холбоосоор орж үнэгүй татаж аваарай <http://www.mozilla-europe.org/en/firefox>)
- Сургалтын материалыг мөн Google Chrome интернетийн хөтөч програмаар үзэх боломжтой (дараах холбоосоор орж үнэгүй татаж аваарай <https://www.google.com/intl/en/chrome/browser/>)
- Техникийн шалтгааны улмаас Internet Explorer програмыг ашиглахгүй байхыг зөвлөж байна.
- JavaScript, Cookies зэргийг идэвхжүүлсэн байх шаардлагатай.

Цахим хичээл ажиллах талбар: Windows 95, 98, 2000, NT, ME, XP эсвэл superior; MacOS 9 эсвэл MacOS X Hardware: 64 MB-ын RAM, 1 GB-ын зайтай байх,

Модем: 128 К

“Ногоон эдийн засгийн үндэс” цахим хичээл талаар
дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар хандана
уу?

НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн Ногоон хөгжил,
ур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөр,

Олон улсын байгаль орчны байр,
Chemin des Anémones 11 – 13
CH-1219 Châtelaine-Женев хот
Швейцар улс

И-мэйл: page@unitar.org

Цахим хуудас: www.unitar.org

НҮБ-ын НЭЗТТ-ийн талаарх
дэлгэрэнгүй мэдээлэл авахыг
хүсвэл доорх хаягаар хандана уу?:

НЭЗТТ-ийн нарийн бичгийн дарга,
НҮББОХ/Эдийн засаг ба
Худалдааны салбар

11 – 13 Chemin des Anémones CH-
1219 Châtelaine- Женев хот,
Швейцар улс



www.un-page.org



@PAGEExchange



@GreenEconomyUNEP



un-page.org/newsletter

www.un-page.org